

БАТЛАВ

“КАДСҮРВЭЙ” ХХК-ын захирал



С.Ганчимэг

“КАДСҮРВЭЙ” ХХК-ИЙН 20 ЖИЛИЙН ОЙ ХҮРЭЭНД АВТО ЗАМЫН БОЛОН ГЕОДЕЗИЙН ИНЖЕНЕРЭЭР СУРАЛЦАЖ БУЙ ОЮУТАН, ЗАЛУУЧУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Сэдэв: “Авто замын геодези”

Авто замын болон геодезийн чиглэлээр суралцагч, оюутан залуусын дунд мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор илтгэлийн уралдаан зарлаж байна.

Зорилго:

Энэхүү илтгэлийн уралдаан нь авто замын болон геодезийн чиглэлээр суралцаж буй оюутан, залуусын онолын мэдлэгийг гүнзгийрүүлэх, судалгаа шинжилгээний ур чадварыг хөгжүүлэх, шинэлэг санаа, шийдлийг дэмжихэд оршино. Монголын Авто Замчдын Холбоо болон Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Мэргэжлийн Холбоо-той оюутан залуусыг холбож, мэргэжлийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой.

Хамрах хүрээ:

Энэхүү илтгэлийн уралдаанд геодези, авто зам, барилга, газар зохион байгуулалт, зураг зүйн чиглэлээр суралцаж буй их, дээд сургуулийн оюутан, залуус оролцох боломжтой. Илтгэл нь авто замын геодезийн онол, практик, шинэ технологи, инновацын шийдлийг хамарсан байна.

Сэдвийн агуулга:

Илтгэл нь “Авто замын геодези” сэдвийн хүрээнд дараах чиглэлүүдийг хамарч болно. Үүнд:

- Авто замын трасс тогтоолт, төлөвлөлтийн геодезийн үндэс
- Инженер геодезийн хэмжилт, боловсруулалтын орчин үеийн арга, технологи
- GNSS, дрон, лазер сканнер зэрэг дэвшилтэт технологийн хэрэглээ
- Авто замын барилгын явц дахь геодезийн хяналт, мониторинг
- Замын ашиглалтын үеийн деформаци, суулт, шилжилтийн судалгаа
- Геодезийн өгөгдөл боловсруулах программ хангамжийн хэрэглээ
- Авто замын геодезийн ажлын чанар, стандарт, норм дүрэм
- Шинэлэг санаа, инновацын шийдэл, судалгааны үр дүн

Илтгэл ирүүлэх хугацаа:

- 1-р шат: **2026 оны 05 дугаар сарын 03**
- 2-р шат (шалгарсан оролцогчид): **2026 оны 05 дугаар сарын 10**

Илтгэлүүдийг цахим болон биечлэн хүлээн авна. Цахим илтгэлийг cadsurveyllc20@gmail.com -ийн имэйлээр ирүүлнэ.

Оролцогчид илтгэлээ цагт нь ирүүлэхийг анхаарна уу.

Шагнал, урамшуулал:

Илтгэлийн уралдаанд шилдэг бүтээлүүдэд дараах шагналууд олгоно:

- **1-р байр:** 3,000,000₮ ӨРГӨМЖЛӨЛ
- **2-р байр:** 2,000,000₮ ӨРГӨМЖЛӨЛ
- **3-р байр:** 1,000,000₮ ӨРГӨМЖЛӨЛ

Хамтран зохион байгуулагчид:

- Монголын Авто Замчдын Холбоо
- Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Мэргэжлийн Холбоо

Ерөнхий ивээн тэтгэгч, ерөнхий зохион байгуулагч:

- “КАДСУРВЭЙ” ХХК

Та бүхнийг идэвхтэй оролцож, мэдлэг чадвараа сорихыг урьж байна.

Жич: Уг илтгэлийн уралдаантай холбоотой мэдээллийг 88010889, 95098868 дараах утсаар асууж лавлаж болно.

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ,
ЕРӨНХИЙ ЗОХИОН
БАЙГУУЛАГЧ:



ХАМТРАН ЗОХИОН
БАЙГУУЛАГЧ:

